

СУМАДИРАДНААГИЙН НЭГЭН  
ГАР БИЧМЭЛИЙН ТУХАЙ

Д. Бүрнээ\*

Нэрт толь зүйч Сумадираднаагийн Улусанринчен\ 1821-1907\ 1857 онд зохиосон “Төвд монголын дохионы бичиг нэр үг утга гурвыг тодруулан харанхуйг арилгагч зул” нэрт толь бичигтэй холбоотой байж болох нэгэн гар бичмэл эдүгээ ОХУ-ын Санкт-Петербургийн их сургуулийн Дорно дахины факультетийн номын санд хадгалагдаж байна. Сумадираднаагийн толийн жинхэнэ эх олдохгүй байгаа өнөө үед энэ гар бичмэл бидний анхаарлыг татсан болно.

Тус гар бичмэл нь “*čoolγ-a-yin dačang -un siregetü ba surγuli-yin baysi nomtuyin olan jüil toli bičig-ü-d-i üjejü ali oldaysan üges-ün tayilburi nemeri-in yosuγar qabsurqaysan töbed mongγol kel-en-ü toli bičig orusiba*” хэмээх нэртэй, орос цаасан дээр бичсэн найман дэвтэр гар бичмэл юм. Цуулгын дацангийн ширээт ба сургуулийн багш Номт хэмээн энд нэр дурдагдаж буй хүн бол Номтын Ринчен буюу Сумадираднаа болно. В.Успенский тус гар бичмэлийн зохиогч, бүтцийн талаар монгол номын бүртгэлдээ мэдээлжээ.

Санкт-Петербургийн их сургуулийн дорно дахины факультетийн номын сангийн эрхлэгчээр ажиллаж байсан монголч эрдэмтэн З.К.Касьяненко гуай тус гар бичмэлийн нэгдүгээр дэвтрээс 16 нүүрийг хэдэн жилийн өмнө хуулбарлан надад явуулсан юм. Энэ гар бичмэлд төвд үгийн доор монгол орчуулгыг хадаж бичихээс гадна ихэнхи үгд монгол тайлбар бичжээ. Тус нооргийн эхний хуудас “Дөрвөн хэлний толь”-ийн “дэвших улирах зүйл”- тэй тулгаж үзэхэд таарч байв. “Дөрвөн хэлний толь”-оос зөвхөн хоёр хэлний үг тухайлбал төвд үгийг толгой үгд авч, дүйх монгол хэллэгийг доор нь хаджээ. “Дөрвөн хэлний толь”-ийн “дэвших улирах зүйл”-д нийт 32 толгой үг хэллэг орсон байдгаас Сумадираднаа наймыг нь хасаж бусдыг авсан байна. Энэ хассан үг хэллэг нь үүлмүй, явсан явдал, буруушаамуй, фүнлү хасмуй, буулгамуй, баймуй, байлгамуй, эвдмүй эдгээр болно.

Тус гар бичмэлийн нэг онцлог бол монгол үг хэллэг бүрт монгол тайлбар бичсэн явдал юм. Ингэхдээ тайлбарыг “Хорин нэгтийн толь”-оос авсан байна. Жишээ нь: дэвшмүй гэсэн үгийг

\* Монгол Улсын Их Сургуул, Монгол хэл, соёлын сургууль

түшмэлийн зэрэг нэмэхийг дэвшмүй хэмээмүй. Бас өндөрийн дээш авирахыг мөн дэвшмүй хэмээмүй гэжээ. Сумадираднаагийн энэ аргыг хожим “Гучин зургаатын тайлбар” толийг зохиогчид хэрэглэсэн байдаг. Энэхүү гар бичмэлд орсон үг хэллэгийг Сумадираднаагийн 1857 онд зохиосон “Төвд монголын дохионы бичиг нэр үг утга гурвыг тодруулан харанхуйг арилгагч зул” нэрт төвд монгол толь бичигтэй тулган үзвэл зохиогч энэхүү гар бичмэлийг эх ноорог болгон ашигласан болох нь харагдаж байна. Иймээс бид Сумадираднаа төвд монгол толь бичгээ зохиохдоо “Дөрвөн хэлний толь” болон “Хорин нэгтийн тайлбар толь”-ийг яаж бүтээлчээр ашигласныг авч үзье. Бид гар бичмэлд монгол бичгээр бичсэн жишээг кириллээр буулгав. “Хорин нэгтийн толь”-ийг “ХНТ”, Сумадираднаагийн “Төвд монгол толь”-ийг “ТМТ”, Сумадираднаагийн гар бичмэлийг “ГБ” гэж товчлов.

“ГБ”-д *gyud* ‘*thud* гэсэн үгийг “залгамжилмуй” гэж орчуулаад “залгамжлах түшмэлийг биед болгохыг залгамжилмуй хэмээмүй. Бас дээс утасны тасарсныг нийлүүлэн уях ба огцорсон юмыг залгах ба охор юмд нэмэхийг цөм залгамуй хэмээмүй” гэж тайлбарлажээ. “ХНТ”-д “залгамжилмуй, үе залгамжлах түшмэлийг биед болгохуйг залгамжилмуй хэмээмүй. *Залгамуй*, дээс утасны тасарсныг нийлүүлэн уях ба огцорсон юмыг залгах ба охор юманд нэмэхийг залгамуй хэмээмүй” гэжээ. “ТМТ”-д *gyud* ‘*thud* залгамжлах нь үе залгамжлах түшмэлийг бие дор болгохыг залгамжилмуй. Бас дээс утасны тасарсныг нийлүүлэн уях ба огцорсон юмыг залгах ба охор юманд нэмэх мэтийг цөм залгамуй хэмээмүй” гэжээ. Эндээс үзвэл Сумадираднаа “ХНТ”-ийн “залгамжилмуй”, “залгамуй” гэсэн хоёр үгийн тайлбарыг “залгамжилмуй” хэмээх үгийн тайлбарт нэгтгэн оруулжээ. Ингэхдээ “үе” гэсэн үгийг “ГБ”-д хассан бол, “ТМТ”-д “үе” гэсэн үгийг оруулж, “бас”, “цөм” гэсэн үгсийг нэмж бичжээ.

“ГБ” – “*khag khyag* баталмуй, сайн хэмээн гарган айлтгахыг батламуй хэмээмүй. Бас хоёрын хооронд дор гэрээ болох мөн батламуй хэмээмүй”.

“ХНТ”- “бэхлэн сахихуйг батламуй хэмээмүй. Бас хүмүүнийг сайн хэмээн гаргах ба аливаа хэрэгт гэрээ болох зэргийн зүйлийг цөм батламуй хэмээмүй. Сайн хэмээн гарган айлтгахыг батламуй хэмээмүй. Бас хоёрын хооронд болохыг мөн батламуй хэмээмүй”. “ТМТ”-д “*khag khyag*- батлах нь түшмэлд сайн хэмээн гарган айлтгах ба хоёрын хооронд гэрээ болохыг мөн батлах хэмээмүй” гэжээ.

Энд “ХНТ” -оос “бэхлэн сахихуйг батламуй хэмээмүй” гэсэн тайлбарыг хасаж, “ГБ” -ийн тайлбарын найруулгыг бага зэрэг өөрчилж, “батламуй” гэснийг “батлах” гэж бичээд тайлбарлаж буй үгээ тодотгосон “нь”, “түшмэлд” зэрэг үгийг нэмжээ.

“ГБ”- ‘*os tho mgo ma* - тухайлмуй, тэргүүн дор болгож жагсаан бичихүйг тухайлмуй хэмээмүй” гэсэн тайлбарыг “ХНТ”-оос ямарваа нэг засваргүй хуулан авчээ. Харин “ТМТ”-д “тушаал яамын тэргүүнд болгож жагсаан сонгон бичихүйг тухайлмуй” хэмээн юуны тэргүүн болгохыг нь тодотгож “тушаал яамын” гэсэн үгийг нэмснээс гадна “жагсаан бичихийг” тодотгосон “сонгон” гэсэн үгийг нэмжээ.

“ГБ”- ‘*os tho gsham ma* - жагсаамуй, олон түшмэдийн нэр зэргийг бичиж айлтгахыг жагсаамуй хэмээмүй. “ХНТ”-ийн тайлбартай яг адил байна. Харин “ТМТ”-д “олон түшмэдээс гурвыг сонгож дээш дэвшүүлэхийн тул түшмэлийн нэр зэргийг бичиж айлтгахаас сүүлийн нь болой”

гэжээ. Энд Сумадираднаа “ХНТ”-ийн тайлбарыг өөрчилж түшмэлийн нэрийг жагсаах төдий бус харин түшмэдээс нэр дэвшүүлэхийн тулд гурвыг сонгоод тэр дотроос сүүлийн түшмэлийн нэр айлтгахыг хэлнэ гэж тайлбарлажээ. Сумадираднаа “тухайлмуй” /'os tho mgo ma/, “дашлуулмуй” /'os tho de 'og/, “жагсаамуй” /'os tho gsham ma/ гэсэн үгийн үндсэн утгыг хадгалсан 'os tho гэсэн үгийг “ТМТ”-доо толгой үгээр оруулж “аль зохистны тэмдэг, лам ноён талбих зохистон” гэж тайлбарлаад, мөнхүү үг орсон pes zi'i 'os tho babs pa'i sras гэсэн өгүүлбэрийг “бэйсийн сонгох зохистны тэмдэг буусан агъ” гэж орчуулжээ. Цаашилбал: ГБ- rgyan 'phen -шивага татмуй, орныг шивага дор бичиж, бүгд хонгионд талбиж, олон /хүн/ татан авах, ХНТ- шивага татмуй- ороныг шиваганд бичиж, бүгд хонгио дор талбиж, олон хүмүүн татан авахыг шивага татмуй хэмээмүй, ТМТ-шивага татах нь орыг шивага дор бичиж, бүгд хонгио дор талбиж, олноор татан авах гэсэн жишээнээс үзвэл “хүн” гэсэн үгийг хасч, “татмуй” гэсэн үгийн нөхцлийг өөрчилж “татах” болгожээ.

Ийнхүү “'ooly-a-yin dačang -un siregetü ba suryuli-yin baysi nomtuyin olan jüil toli bičig-üd-i üjeju ali oldaysan üges-ün tayilburi nemeri-in yosuyar qabsurqaysan töbed mongyol kelen-ü toli bičig ogusiba” хэмээх гар бичмэлийг “Төвд монголын дохионы бичиг нэр үг утга гурвыг тодруулан харанхуйг арилгагч зул “ нэрт толь бичигтэй харьцуулж үзвэл, Сумадираднаа дээрх гар бичмэлийг үндэс болгож төвд монгол алдарт толь бичгээ зохиосон болох нь харагдаж байна.

#### Резюме

В этой статье автор сравнивает слова и выражения из фрагмента рукописи, принадлежащей перу Номту Ринчена \Сумадиридна\ со словами и выражениями из его же знаменитого тибето-монгольского словаря, оригинал которого не обнаружен до сих пор. Рукопись находится в хранении библиотеки Восточного факультета, Санкт-Петербургского университета. Идентичность слов и выражений из рукописи со словами и выражениями “Хорин нэгтийн толь” и “Дөрвөн хэлний толь” показывает, что до составления тибето-монгольского словаря автор составил черновик, которой он пользовался при составлении своего знаменитого словаря.

